


- Өнгийг харагдах байдлаар ахроматик буюу хроматик өнгө гэж ангилдаг. Ахроматик өнгөнүүдтэй хариуг сонгоно уу.
 А. улаан, шар, цэнхэр зэрэг өнгө
 В. хар, цагаан, саарал зэрэг өнгө
 С. улаан, хөх, ногоон зэрэг өнгө
 D. хар, бор, улбар шар зэрэг өнгө
- Цагаан, саарал, хар өнгөнүүдээс бусад өнгөнүүдийг ямар өнгө гэж нэрлэдэг вэ? Зөв хариуг сонгоно уу.
 А. хроматик өнгө
 В. ахроматик өнгө
 С. дулаан өнгө
 D. хүйтэн өнгө
- Хөх, улаан, шар өнгөнүүдийг хооронд нь харьцуулахад харилцан бараан, цайруу харагдах байдал нь өнгийн юуг илэрхийлэх вэ? Зөв хариуг сонгоно уу.
 А. өнгийн харшил
 В. өнгийн тон
 С. өнгийн ханалт
 D. өнгийн дагнаас
- Өнгийн хоршил гэсэн ойлголтыг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.
 А. Өнгө дээд хэмжээндээ хүртэл тодорсныг хэлнэ.
 В. Бүх өнгийн бүтцийг нийлэмж цогц болгож байгаа ерөнхий өнгийг хэлнэ.
 С. Өнгөнүүд харилцан нийлэмжтэй болж зохицохыг хэлнэ.
 D. Өнгөнүүд харилцан бараан, цайруу харагдах байдлыг хэлнэ.
- Хэт ойр байгаа зүйлс болон уудам орон зайд байгаа зүйлсийг дээрээс харсан байдлаар зурах үед ихэвчлэн ашигладаг бөгөөд ямар нэгэн тогтсон байгуулалтын зарчмаар зурдаггүй алслалтын аргыг сонгоно уу.
 А. нэг цэгийн алслалт
 В. хоёр цэгийн алслалт
 С. өнгийн алслалт
 D. урвуу алслалт
- Зургийн өнгийг ажиглаад, тохирох өнгийн зохицлыг сонгоно уу.



- ахромат өнгө
- зонхилох өнгө
- хүйтэн өнгө
- хромат өнгө

- Аливаа бодит зүйлсийг зургийн хавтгай дээр орон зайтай болгон зурахад нэг, хоёр, гурван цэгийн алслалтын байгуулалтын аргыг ихэвчлэн ашигладаг. Хоёр цэгийн шугаман алслалтын аргаар дүрсэлсэн барилгын зургийг сонгоно уу.



8. Харааны түвшний шулуун зургийн хавтгайн дээд хэсэгт байгаа зургийг сонгоно уу.



A.



B.




C.




D.

9. Аливаа зүйлсийг бодит байдлаас харж зурахдаа тэдгээр юмсын урт, өндөр, өргөн зэрэг хэмжээг хооронд нь харьцуулан харах шаардлагатай болдог. Зурагт үзүүлсэн цилиндрийн хэмжээ харьцааг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.



- A. Цилиндрийн өргөн өндөртэйгөө тэнцүү.
- B. Цилиндрийн өргөн өндрийн талтай тэнцүү.
- C. Цилиндрийн өргөн өндрийн гуравны нэгтэй тэнцүү.
- D. Цилиндрийн өндөр өргөний дөрөвний нэгтэй тэнцүү.

10. Тосон харандаа (пастель) нь өнгийн харандааны нэг төрөл бөгөөд өнгө уусгах, давхарлах, тод өнгө гаргахын зэрэгцээ усан будагтай хослуулан хэрэглэж болдог онцлог юм. Тосон харандаагаар зурсан зургийг ажиглаад, зураасны хүнд хөнгөн даралт, нягт сийрэг байдлыг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.




- A. Зурагт шувуудыг хүнд даралтаар сийрэг, замыг хөнгөн даралтаар нягт байдлаар зурааслан дүрсэлжээ.
- B. Зурагт байшинг хөнгөн даралтаар сийрэг, бусдыг нь хүнд даралтаар нягт байдлаар зурааслан дүрсэлжээ.
- C. Зурагт тэнгэрийг хөнгөн даралтаар нягт, модыг хүнд даралтаар сийрэг байдлаар зурааслан дүрсэлжээ.
- D. Зурагт тэнгэрийг хөнгөн даралтаар сийрэг, модыг хүнд даралтаар нягт байдлаар зурааслан дүрсэлжээ.


11. Урвуу алслалт гэдэг нь юмс ажиглагчаас холдох тусам жижгэрч багасдаг зарчмыг эсрэгээр нь болгож зурах арга юм. Урвуу алслалтын аргыг харуулсан жишээ зургийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

12. Өнгийн зохиомжийн нэршлийг жишээ зурагтай зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1. өнгийн ханалт

2. хроматик өнгө

3. өнгийн дагнаас



A.



B.



B.

A. 1-B, 2-A, 3-B

B. 1-A, 2-B, 3-B

C. 1-A, 2-B, 3-B


D. 1-B, 2-B, 3-A

13. Хүн, амьтан, араатан жигүүртэн зэрэг сээр нуруутан амьтад нь цөм араг ястай байдаг. Араг яс нь тэр амьтны гадаад хэлбэр дүрсийг тогтоож өгдөг. Морийг хажуу талаас нь дүрсэлсэн аргуудыг зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.

1. бодит дүрсийн хайчилбар

2. загварчлан дүрсэлсэн


3. бүдүүвчлэн дүрсэлсэн



A.



B.



B.

A. 1-B, 2-B, 3-A

B. 1-B, 2-A, 3-B

C. 1-A, 2-B, 3-B

D. 1-B, 2-A, 3-B

14. Сурагч Э.Нансалмаа зураг зурах сонирхолтой. Тэр зургийн хичээлээрээ нэгэн бяцхан цөөрөм дээр зүг бүрээс цангасан үхрүүд ирж нэгнээсээ өрсөн ус ууж байгаагаар зуржээ. Сурагчийн бүтээлийг ажиглаад, зургийн зохиомж болон дүрүүдийн онцлогийг зөв тодорхойлсон хариуг сонгоно уу.



Э.Нансалмаа нас 12. “Цангасан үхрүүд”. 2003 он. Гуаш, цаас.

- A. Зургийг хүннүгийн үеийн эгц дээрээс харсан “Морьт тэрэг” зурагтай ижил аргаар, цөөрмийг гол төв болгон, ус ууж буй үхрүүдийг ахроматик өнгөнүүдээр дүрсэлжээ.
- B. Зургийг монгол зургийн шувууны нислэгийн өндрөөс харсан мэт дүрсэлдэг аргаар, цөөрмийг гол төв болгон, ус ууж буй үхрүүдийн зан төрхийг өөр өөрөөр байдлаар дүрсэлжээ.
- C. Зургийг юмс ажиглагчаас холдох тусам жижгэрч багасдаг зарчмын дагуу нэг цэгийн алслалтын аргаар, цөөрмийг гол төв болгон, ус ууж буй үхрүүдийг өөр өөрөөр өнгөөр дүрсэлжээ.
- D. Зургийг юмс ажиглагчаас холдох тусам жижгэрч багасдаг зарчмыг эсрэгээр нь болгож зурах буюу урвуу алслалтын аргаар, үхрүүдийг гол төв болгон, ус ууж ханасан болон ус ууж байгаа байдлаар дүрсэлжээ.
15. Зурааслах арга нь аливаа юмсыг гэрэл сүүдэртэй орон зайтай болгон харагдуулдаг гол аргуудын нэг юм. Биетийн гэрэлтэй хэсгийг зурааслах аргыг сонгоно уу.
- A. хөнгөн даралтаар, нягт
B. хүнд даралтаар, нягт
C. хүнд даралтаар, сийрэг
D. хөнгөн даралтаар, сийрэг
16. Үсгийг хэв маягаар нь уран сайхан үсэг, антиква-хэрчмэл үсэг, гротеск-дармал үсэг гэж ангилдаг. Гротеск төрлийн үсгийн зураасуудыг сонгоно уу.
- A. үндсэн ба холбох зураас
B. холбох ба нуман зураас
C. үндсэн ба шулуун зураас
D. холбох ба тахир зураас
17. Богино хугацаанд аливаа зүйлийн дүр төрх, гол санааг илэрхийлж, хурдан дүрсэлдэг зургийн төрлийг сонгоно уу.
- A. таталбар зураг
B. судалбар зураг
C. тойм зураг
D. хар зураг
18. Бурхан дүрслэх харьцаа хэмжээ, биеийн хөдөлгөөн, суудал, нүүр царай, эдлэл, чимэглэл зэргээр шашин номын утга, гүн ухааны үзэл санааг илэрхийлэн, тигийн аргаар дүрсэлдэг зургийн төрлийг сонгоно уу.
- A. зураасан зураг
B. ардын зураг
C. шүтээн зураг
D. монгол зураг


19. Аливаа юмсыг гэрэл сүүдэртэй орон зайтай болгон харагдуулдаг гол аргуудын нэг нь зурааслах арга юм. Геометр биетийн гэрэл, сүүдрийг зурааслах аргаар дүрсэлсэн зургийг сонгоно уу.



A.



B.



C.




D.


20. Гротеск-дармал хэв маягаар бичигдсэн үсгийг сонгоно уу.




A.



B.




C.




D.

21. Түргэн зураг гэдэгт таталбар, судалбар зураг ордог. Таталбар зургийн аргаар зурсан зургийг сонгоно уу.




A.



B.



C.



D.

22. Байгалийн өнгө төрхийг өнгөөр илэрхийлэн зурсан судалбар зургийг сонгоно уу.



A.



B.



C.



D.

23. Ардын зурагт дагнааслах, самнаж зурах, замхруулан шавших, хээлж, угалзлах сүүдэртүүлэн дүрслэх зэрэг олон арга ашигладаг. Дүрслэх урлагийн бүтээлүүдээс ардын зургийг сонгоно уу.



A.



B.




C.



D.


24. Гэрэл сүүдрийн хэсэг тус бүр өөрийн нэршилтэй бөгөөд хүнд хөнгөн байдлаараа харилцан адилгүй байдаг. Биет зурахдаа ойр байгаа биеийн гэрэл сүүдрийн заагийг тод зураасаар холдох тусам бүдгэрүүлэн зурдаг. Гэрэл сүүдрийн бүсүүдийн дугаарыг тайлбартай нь зөв харгалзуулсан хариуг сонгоно уу.



- А. Гэрэл эгц туссан хамгийн тод гэрэлтэй хэсэг буюу гэрлийн гялаан гэнэ.
 Б. Тухайн биетийн сүүдэр байршлын хавтгай дээр туссан хэсэг буюу унасан сүүдэр гэнэ.
 В. Гэрэл аажим бүдгэрч сүүдэртэх хэсэг буюу хагас сүүдэр гэнэ.

А. 1-В, 2-Б, 3-А В. 1-Б, 2-А, 3-В С. 1-А, 2-В, 3-Б Д. 1-В, 2-А, 3-Б

25. Монголчуудын бурхан шашны соёл түүхэнд гардаг нэгэн шүтээн бол цагаан өвгөний дүр юм. Цагаан өвгөний дүрийг ямар аргаар урлан бүтээсэн байна вэ? Бүтээлд тохирох хариуг сонгоно уу.



- А. Дүрслэх харьцаа хэмжээ, царай зүс, өнгө будаг зэрэг нь бурханы номын тодорхой утга санаа, гүн ухааны чиглэлээр тигийн аргаар зурагдсан шүтээн зураг.
 В. Наах аргаар урлаад хөвөөгөөр нь зээг тавьж хийдэг нэгэн зүйл гар урлал зээгт наамлын аргаар нааж, оёж урласан бүтээл.
 С. Найрлага сайтай шингэн зуурмагаар төрөл бүрийн материалыг давхарлан нааж, хэвийн зүмбэрлэх аргаар урласан бүтээл.
 Д. Тусгай бэлтгэсэн хэв дээр, цаасыг олон дахин нааж товойлгон, цаасан шуумлын аргаар урласан хагас товгор бүтээл.